



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

### “Талын салхи” олон улсын мото наадам зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, “Талын салхи” олон улсын мото наадам зохион байгуулах тухай нийслэлийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/545 дугаар захирамж, газрын дүрмийн 7.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох зорилгоор “Талын салхи” олон улсын мото наадмыг 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбай болон “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолборт зохион байгуулсугай.

2. “Талын салхи” олон улсын мото наадмыг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 56,500,000 /тавин зургаан сая таван зуун мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Уянга/-д зөвшөөрсүгэй.

4. Арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Ажлын хэсэг /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА


*D. Batuy*

Д.БАТСҮХ



21515 015


Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2023 оны 06 сарын 05 өдрийн  
А/27 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**“ТАЛЫН САЛХИ” ОЛОН УЛСЫН МОТО НААДАМ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:	В.Батчимэг	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
Гишүүд:	С.Туул	Маркетинг, сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн
	Н.Алтанзаяа	Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн
	Б.Цолмонгэрэл	Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан мэргэжилтэн
	Б.Мичидмаа	Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүд хариуцсан менежер
	Д.Сайханчимэг	Мэдээллийн технологи, цахим хөгжил хариуцсан ажилтан
	Т.Батдорж	Дотоодын аялал хариуцсан мэргэжилтэн
	П.Хатанбаатар	“Чингис мото клуб” НҮТББ тэргүүн
	Б.Анхбаяр	“Чингис мото клуб” НҮТББ
	О.Хашболд	“Чингис мото клуб” НҮТББ
Нарийн бичгийн дарга:	Б.Үржинханд	Эвент хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2023 оны 06 сарын 05 өдрийн  
A/27 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



“ТАЛЫН САЛХИ” ОЛОН УЛСЫН МОТО НААДАМ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
Талбайн тохижилтын зардал				
1	Лед дэлгэц, хөгжим техник, карказ, гэрэлтүүлэг /Чингис хааны хүрээ/	Багц	15 000 000	15 000 000
2	Асар майхан түрээс /5*5/	20ш	125 000	2 500 000
3	Сандал түрээс	300ш	3500	1 050 000
4	Цахилгааны төлбөр	-	400 000	400 000
5	Талбайн хөгжим техник /Сүхбаатарын талбай/	Багц	4 000 000	4 000 000
6	Гадаад тамирчдын хоолны зардал	250	32 000	8 000 000
Хэсгийн дүн				30 950 000
Мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр				
1	Арга хэмжээний шторк бэлтгэх	30сек	1 500 000	1 500 000
2	Контент бэлтгэх	Багц	5 000 000	5 000 000
3	Телевизүүдээр арга хэмжээний шторк цацалт	6ш	500 000	3 000 000
4	Асарын хөмсөг, хаяг хэвлэлт, эх бэлтгэл	20ш	62.500	1 250 000
Хэсгийн дүн				10 750 000
Зохион байгуулалтын чиглэлээр				
1	Урлагийн тоглолт	Багц	10 000 000	10 000 000
2	Хөтлөгч	1 хүн, 1 өдөр	2 000 000	2 000 000
3	Өргөмжлөл	20ш	40 000	800 000
4	Мерчиндайзийн зардал	Багц	2 000 000	2 000 000
Хэсгийн дүн				14 800 000
Нийт дүн				56 500 000

--- оОо ---